



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/08

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Сумын төвийн тохижилт /Ховд, Дөргөн сум-2 дугаар багц Усны машин нийлүүлэх” ажлын гүйцэтгэгч “Тэнчи” ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганболд – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдагын хэлтсийн дарга

Гишүүд: Т.Дариймаа – Дөргөн сумын Засаг даргын орлогч
Б.Баттогтох – Дөргөн сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Л.Батгэрэл -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Б.Түмэнжаргал – Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. “Сумын төвийн тохижилт /Ховд, Дөргөн сум-2 дугаар багц Усны машин нийлүүлэх” ажлын гүйцэтгэгч “Тэнчи” ХХК-ний ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Ганболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Т.ЖАРГАЛСАЙХАН



02 00023
D/Zax.A/08.Da